Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Т.Айтуган танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 16-аас 2022 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэв.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/99 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүний нөөц, газар, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

“Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацад нийцсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, “хадлан бэлчээрийн нөөцийг сайжруулж, бэлчээр ашиглалтын хамтын менежментийг төлөвшүүлэх”, “жигжиг дунд үйлдвэрийг сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх”, “аялал жуулчлалыг сумын эдийн засгийн нэг үндсэн салбар болгон хөгжүүлэх”, “сумын нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын нөөцийг ашиглах урьдчилсан нөхцөлийг хангах”

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын төсвөөс санхүүжидэг байсан Цэнгэл сумын Сум дундын эмнэлэг нь бүтцийн өөрчлөлтөөр 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс сумын Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн мэдэлд шилжиж, сумын Эрүүл мэндийн төв болж өөрчлөгдөн, ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд орсон байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5955.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 59.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 41.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 285.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 201.6 сая төгрөг болж, 83.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	285.3	201.6	-83.7	29.3
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>285.3</b>	<b>201.6</b>	<b>-83.7</b>	<b>29.3</b>

*Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 201.6 сая төгрөг байгаагаас 90.0 сая төгрөг нь сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 78.1 сая төгрөг нь ОНХСангийн, 19.8 сая төгрөг нь СХСангийн, 11.9 сая төгрөг нь БОХС, 1.6 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын, 0.2 сая төгрөг арилжааны банкинд дахь Эргэлтийн эмийн сангийн дансны үлдэгдэл байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Тус сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 392.0 сая, эцсийн үлдэгдэл 443.9 сая төгрөг болж, 51.9 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	18.5	6.7	-11.8
Төлбөртэй үйлчилгээний авлага		58.9	58.9
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	0.8	15.0	14.2
Зээлийн авлага	372.7	363.3	-9.4
<b>Дүн</b>	<b>392.0</b>	<b>443.9</b>	<b>51.9</b>

Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 363.3 сая төгрөг байгаа нь нийт авлагын 81.8 хувийг эзлэж, тайлант онд авлагын эргэн төлөлтөөс барагдсан хэмжээгээр авлагын дүн буурсан байна. Зээлийн хүүгийн авлагаас 8.6 сая төгрөгийг тусгаж ирүүлсэн байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 58.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлага шинээр нэмэгдэж, ажиллагсадтай холбоотой ЕБ-ын 1-р сургууль 2.0 сая, 2-р сургууль 1.3 сая, Хүүхдийн 1-р цэцэрлэг 15.0 сая, 4-р дүгээр цэцэрлэг 3.4 сая нийтдээ 80.6 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Төсөвт байгууллагын авлага нэмэгдэхэд ЭМТ-ийн авлага нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 178.9 сая, эцсийн үлдэгдэл 292.0 сая төгрөг болж, 113.1 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал		18.7	18.7
Хангамжийн материал	177.1	230.5	53.4
Мал амьтад	1.8	0.0	-1.8
Нөөцийн бараа		42.8	42.8
<b>Дүн</b>	<b>178.9</b>	<b>292.0</b>	<b>113.1</b>

Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 178.9 сая төгрөг болж 113.1 сая төгрөгөөр өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн бараа материалын үлдэгдэл нэгтгэлд орсон нь нөлөөлсөн байна.

Сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 577.7 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 72.6 сая төгрөгийн материал үнэгүй төлбөргүй, бүтцийн өөрчлөлтөөр 36.4 сая төгрөгийн нийт 686.7 сая төгрөгийн материал хүлээн авч данс бүртгэлд тусган, үйл ажиллагаандаа 554.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 18.7 сая төгрөгийн материалыг акталсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 94.8 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулиудын, 82.2 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгүүдийн, 65.3 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 49.7 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна.

Сумын ЭМТ-ийн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсантай холбоотой материалын үлдэгдэлээр, сумын ЗДТГ-т ОНХС-гийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн тэжээлийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой тус тус нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар бараа материалын дансадтай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 16557.8 сая, эцсийн үлдэгдэл 17656.3 сая төгрөг болж, 1098.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,631.7	11,555.2	923.5
Биет бус хөрөнгө	203.4	214.6	11.2
<b>Дүн</b>	<b>10,835.1</b>	<b>11,769.8</b>	<b>934.7</b>

*Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 91.6 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1053.1 сая, бүтцийн өөрчлөлтөөр 1382.1 сая, шилжүүлэн авсан 4.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 231.6 сая төгрөгийн хөрөнгө акталж, 24.4 сая төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжүүлсэн байна. Дуусаагүй барилга дансны үлдэгдэлгүй гарсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансадтай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7.2 сая, эцсийн үлдэгдэл 89.1 сая төгрөг болж, 81.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт: №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------	-----------------

Ажилчидтай холбогдсон өглөг		51.8	51.8	58.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг		4.7	4.7	5.3
Байгууллагад төлөх өглөг	4.0	30.5	26.5	34.2
Хувь хүмүүст төлөх өглөг	3.2	2.1	-1.1	2.4
<b>Нийт дүн</b>	<b>7.2</b>	<b>89.1</b>	<b>81.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 89.1 сая төгрөгийн 58.1 хувийг буюу 51.8 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой, 34.2 хувийг буюу 30.5 сая төгрөгийг байгууллагад төлөх, 5.3 хувь буюу 4.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний, 2.4 хувь буюу 2.1 сая төгрөгийг хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

Сумын ЭМТ Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилттэй холбоотой 87.0 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэж, ЕБ-ын 2 дүгээр сургууль 5.1 сая төгрөгийн оны эхний үлдэгдлийг барагдуулж, Хүүхдийн 4-р цэцэрлэг оны эхний 2.1 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар өглөгтэй холбоотой дараах зөрчил дутагдал гарсан байна. Үүнд:

Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль тайлант онд цалингаас нийтдээ 27.8 сая төгрөгийн татвар суутган авч 25.2 сая төгрөгийг төсөвт төлж, 2.7 сая төгрөгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байсныг төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,038.3	2,865.5	827.2	22.7
Хуримтлагдсан үр дүн	6,222.8	5,565.5	-657.3	44.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,423.1	4,187.2	764.1	33.2
<b>Дүн</b>	<b>11,684.2</b>	<b>12,618.2</b>	<b>934.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс 827.2 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 764.1 сая, хуримтлагдсан үр дансны үлдэгдлүүд 499.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь бүтцийн өөрчлөлттэй холбоотой, тайлант оны хуримтлагдсан үр дүн 158.1 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.10. Орлогын данс

Цэнгэл сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 243.0 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 5301.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 1105.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 108.8 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 203.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 105.8 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 1125.7 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч, нийтдээ 8193.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 8193.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2196.3 сая төгрөгөөр буюу 36.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн орлого, төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал бүгд нэмэгдэж, шинээр ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

### 3.5.11 Зардлын данс

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 7973.3 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2017.7 сая төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн байна.

Нийт зардлын 96.8 хувь нь бараа үйлчилгээний зардал, 3.2 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшлын зардал, томиллолт, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 0.1-1027.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны оны орлого, зарлагаас ихээхэн хэмжээний өөрчлөлт нь тайлант онд сумын Эрүүл мэндийн төв нэмэгдсэнтэй холбоотой гарч байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар зардлын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.*

*Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд:*

*Засаг даргын тамгын газар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 187.7 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 18.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллагаас 9.8 сая төгрөгийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлж, 8.9 сая төгрөгийн урсгал зардлыг төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 5.5 сая төгрөгийн албаны конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.*

*ЕБ-ын 1-р сургууль үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 143.9 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 14.4 сая төгрөгийг хэмнэж зарцуулахаас 8.6 сая төгрөгийг /цалингийн зардлаас бусад зардлын хэмнэлт/ төсөвт төвлөрүүлж, 5.7 сая төгрөгийн төсвийг хэмнэж, төсөвт төвлөрүүлээгүй.*

*ЕБ-ын 2 дугаар сургууль үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 14.0 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 1.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 1.0 төгрөгийг хэмнэж ажиллаагүй.*

*ЕБ-ын 3-р сургууль үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 6.6 сая төгрөгийн төсвийн 10 хувь 0.6 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож ажиллаагүй байна.*

*ЕБ-ын 2 дугаар сургууль үдийн цай, тээвэр шатахуун, халаалт, гэрэл цахилгааны зардлаас нийтдээ 10.6 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.*

*ЕБ-ын 3-р сургууль цалин хөлс, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардал, бараа*

үйлчилгээний бусад зардал, норматив зардлын нийт 6.2 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант онд гэрэл цахилгааны зардлын тооцоогоор гарсан нийт 2.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Сумын ТШЗ-ийн тайлангаар дээрх зөрчлүүдэд акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн байна.

### **3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Цэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 7060.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6631.6 сая төгрөгийг урсгал зардалд, 429.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 5301.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1106.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 429.1 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 73.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Цэнгэл сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 6814.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 5237.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 1084.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 49.9 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 304.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 139.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 139.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 64.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба орон нутгийн төсвөөс 21.7 сая төгрөгийн, ОНХС-гаас 124.6 сая төгрөгийн, ЭМДС-гаас 24.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 11.0 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6859.2 сая төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Цэнгэл сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 112.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тогтоолоор тус сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 174.3 сая төгрөгөөр буюу 62.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2020 оны хуралдааны 25 дугаар тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 174.3 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 243.0 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 68.7 сая төгрөгөөр буюу 39.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	171.9	195.7	23.9	80.6
II.Татварын бус орлого	2.4	47.2	44.8	19.4
<b>Нийт дүн</b>	<b>174.3</b>	<b>243.0</b>	<b>68.7</b>	<b>100.0</b>

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 2.9 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.2 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 100 хувь тасарсан байна.

Үйл ажиллагааны орлогын албан татвар 11.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 2.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.2 сая, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 10.7 сая, агнуурын нөөцийн төлбөр 3.4 сая, хүү торгуулийн орлого 4.8 сая төгрөгөөр тус тус давж биелэгдэн, төлөвлөгөө өгөгдөөгүй малын албан татварын орлогоос 33.5 сая, бусад нэр заагдаагүй орлогоос 39.9 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Малын албан татварын орлогыг Сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлаагүй, сумын татварын байцаагчийн малын тоо толгойд татварын хэмжээ тогтоосноор Засаг дарга баталж ногдуулалт хийсэн байна. 2022 оноос сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 130.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 243.0 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 90.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

*/сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	96.8	96.4	0.3
2	Сумын ЗДТГ	543.4	523.0	20.4
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2,490.4	2,481.8	8.7
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	615.3	615.0	0.3
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	281.6	281.6	0.0
6	1-р цэцэрлэг	424.7	408.5	16.1
7	2-р цэцэрлэг	296.2	284.2	12.0
8	3-р цэцэрлэг	289.9	281.0	8.9
9	4-р цэцэрлэг	235.9	216.3	19.7
10	Соёлын төв	120.2	120.2	-
11	Эрүүл мэндийн төв	960.7	935.1	25.6
12	Руханият сургууль	126.5	126.5	-
13	ОНХСан	429.1	351.2	77.8
14	СХС	150.0	138.4	11.6
	<b>Нийт дүн</b>	<b>7,060.7</b>	<b>6,859.2</b>	<b>201.4</b>

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ТТЗ-ийн тайлангаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 131.4 сая, дээд шатны төсвийн захирагчаас 72.4 сая төгрөгийн нийтдээ 203.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлс, НДШ-тэй холбоотой зардалд 98.2 сая, бичиг хэрэгт 0.9 сая, тээвэр шатахууны зардалд 9.2 сая, шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 0.5 сая, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалд 1.6 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсд 2.4 сая, эмийн зардалд 13.0 сая, хоол хүнс 0.2 сая, багаж, техник, хэрэгсэлд 7.0 сая, томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд 11.8 сая төгрөгийн, урсгал шилжүүлгийн зардалд 58.8 сая нийтдээ 309.2 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэл сумын Засаг дарга нь 2021 онд нийт 2122.8 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2122.8 сая төгрөгийн 71 мэдээллийг хугацаандаа байршуулж, 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Сумын Төсвийн төлөрүүлсэн захирагчийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн 363.3 сая төгрөгийн авлагын талаарх мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 17 байгууллага, санг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Тухайн ТТЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын дүнгээр 3 байгууллагад зөрчил арилгах зөвлөмж өгөгдсөн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

*Сумын ЗДТГ Шилэн дансанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 43.4 сая төгрөгийн 6 гүйлгээг байршуулаагүй байна.*

ЕБ-ын 2 дугаар сургууль 10.0 сая төгрөгийн өр, авлага үүссэн 2 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 83.3 хувьтай байна.

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 2021 онд нийт 424.6 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 409.4 сая төгрөгийн 147 мэдээллийг хугацаанд байршуулж, 15.5 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, 1 заалт бүхий зөвлөмж өгөгдснийг биелүүлж, биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт: №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				100.0
<b>Нийт</b>	<b>1</b>		<b>1</b>				<b>100.0</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 11 төсвийн байгууллага, 5 тусгай сан, хувийн хэвшлийн 1 сургууль нийт 17 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургууль, Хүүхдийн 1, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, БОХС, хувийн хэвшлийн 1 сургууль тайланд нэгтгэгдсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2411.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2019.4 сая төгрөгийн алдааг залруулга хийж, 391.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдөв.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой 2019.6 сая төгрөгийн залруулгуудыг хийлээ. Үүнд:

- Тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн ЭМТ-ийн бараа материалын эхний үлдэгдэлийг 36.4 сая, үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1382.1 сая, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 309.0 сая төгрөгийн нийтдээ 1727.5 сая төгрөгийг Э тайланд зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

- Тайлант оны үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 72.3 сая төгрөгийн Э-тайланд зарүүтэй ирүүлснийг залруулсан.
- ТТЗ-ийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ЗДТГ, ИТХ-ын орон нутгийн санхүүжилтийг 21.6 сая төгрөгөөр илүү, төсвийн гүйцэтгэлийн зарлагыг ЭМТ-ийн 7.0 сая төгрөгөөр илүү гаргаж ирүүлснийг залруулав.
- ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангаарх нэмэлт санхүүжилтийн тайланг Э-тайланд 191.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

**Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой тайлантай холбоотой 391.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч албан шаардлага, өгөгдлөө.

1. Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн 363.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлийг зээлдэгч бүрээр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс дансанд 139.0 сая төгрөг орсон боловч зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлээс 167.6 сая төгрөг төлөгдсөнөөр хасалт хийж, зээлийн программ дахь үлдэгдлийг 28.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг баталгаажуулах ажил хангалтгүй хийгдсэн байна.

2. Сумын Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн 363.3 сая төгрөгийн авлагын талаарх мэдээллийг оруулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 113.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

Аудитаар ЕБ-ын 1 дүгээр сургуульд 0.7 сая, ЕБ-ын 2 дугаар сургуульд 2.7 сая, Соёлын төвд 0.4 сая төгрөгийн бүгд 3.8 сая төгрөгийн акт тогтоосон.

Сумын ЗДТГ-т 14.4 сая, ЕБ-ын 1 дүгээр сургуульд 5.7 сая, ЕБ-ын 2 дугаар сургуульд 1.0 сая, ЕБ-ын 3 дугаар сургуульд 0.6 сая нийт 21.7 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн.

Сумын ЗДТГ-т 43.4 сая, ЕБ-ын 2 дугаар сургуульд 20.6 сая, 3 дугаар сургуульд 6.2 сая, сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт 15.5 сая, Эрүүл мэндийн төвд 2.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 6 заалттай зөвлөмж хүргүүлсэн байна.

**Хүснэгт 10: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/**

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ЗДТГ	2	57.8					1	14.4	1	43.4
2	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2	6.4			1	0.7	1	5.7		
3	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	4	24.3			1	2.7	1	1.0	2	20.6
4	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	2	6.8					1	0.6	1	6.2
5	Хүүхдийн 1-р цэцэрлэг	1	15.5							1	15.5
6	Соёлын төв	1	0.4			1	0.4				
7	Эрүүл мэндийн төв	1	2.7							1	2.7
<b>Нийт дүн</b>		<b>13</b>	<b>113.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>3.80</b>	<b>4</b>	<b>21.7</b>	<b>6</b>	<b>88.4</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Байхгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэнгэл сумын ТТЗСНТайлан	8	2411.8	7	2019.6			1	391.9		